



1990 оны 11  
сарын 01 өдөр

БНМАУ

У/2

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ

дугаар 265

Улаанбаатар  
хот

Тусгай сургууль  
байгуулах тухай

Налайхын районы хөдөлмөрчдөөс тавьсан хүсэлт хот, районы ардын боловсролын газар, хэлтэс, мэргэжлийн эмч, багш нарын үзлэгийн дунг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Налайхын районд 1990-1991 оны хичээлийн жилд 8 жилийн тусгай 6-р сургууль байгуулж хичээллүүлэхийг Хотын ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.

2. Налайхын районаны АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Лхагва-сүрэн/-д ДААЛГАХ нь:

а/ Орон нутгийнхаа үйлдвэр аж ахуйн газрын онцлог, ажиллах хүчиний хэрэгцээ, оюун ухааны хомсдолтой хүүхдийн боломж, эцэг эхийн санал зэргийг харгалзан хөнгөвчилсөн сургалттай сургуулийн хөдөлмөр-мэргэжлийн сургалтын чиглэл, төрлийг уян хатнаар тогтоож сурагчдад хөдөлмөрийн баримжаа олгох арга хэмжээг авах, хөдөлмөр-мэргэжлийн сургалтыг бааз үйлдвэр, аж ахуйн газартай болгох, бололцоогоо ашиглан сургуулийн дэргэд жижиг, цех, тасагтай болох.

б/ хөнгөвчилсөн сургалттай сургуулийн материаллаг баазаар бэхжүүлж, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, багаж, түүхий эдээр хангах арга хэмжээг орон нутгийнхаа бололцоонд тушиглэн хэрэгжүүлэх.

в/ хэл засал, биөийн тамирын эмчилгээний ганцаарчилсан ба групп хичээлийг хичээлийн бус цагаар тогтмол явуулж ажиллах.

г/ сурагчдын ажил хөдөлмөр, хумуужийн төлөвшилт, бие даан амьдрах арга ухамсар, мэдлэг чиглэлийг тогтооход тусалж, сургууль төгссений дараа ажлын байраар хангаж ажиллах.

МБ

2.

д/амьдралын дорой ар гэрийн гачигдалтай сурагчдад буцалтгүй тэтгэвэр тэтгэмж олгож, аятай нөхцлөөр бүрэн хангах.

3. Налайхын районы эрүүлийг хамгаалах хэлтсийн судалгааг үндэслэн эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эмнэлгийн нарийн мэргэжлийн туслалцаа үзүүлж, ураг төрлийн холбоо ойртсон асуудлыг судлан цаашид мөрдөн ажиллах чиглэл боловсруулан, сурагчдыг эрүүлжүүлэх, эмчлэн сувилах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллахыг Хотын ЭХНХ-ийн газар /н.Бямбаа/-т даалгасугай.

4. Тусгай сургууль байгуулж байгаатай холбогдуулан дотоод тавилга, тооног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 50,0 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхийг нийгэм эдийн засгийн хөгжлийн газар /н.Бат/-д зөвшөөрсүгэй.

5. Шинэ сургуулийн 1990 тесөвт зардалд шаардагдах 40,3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос санхүүжүүлэхийг хотын санхүүгийн газар /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

6. Одооны шинээр орсон II-II жилийн дунд сургуулийн дотуур байрыг ашиглалтанд оруулж 8 жилийн 6-р сургуульд дансаар бурмөсөн шилжүүлэхийг Налайх районаы боловсролын хэлтэс /Барамсай/-д даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ДАРГА - 2

Л.ЭНЭБИШ

ХЭРХТ ЭРХЛЭХ ГАЗРЫН

ХУЛГАТА 2

Ч.СУМААХҮҮ